

ТАНИЛЦУУЛГА

Хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоох ажил, мэргэжлийн жагсаалт, хэрэглэх журам батлах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төсөл боловсруулсан тухай танилцуулга

2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Даатгуулагчид хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоох асуудал нь тухайн үедээ Монгол төрийн нийгмийн хамгаалын бодлогын нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг байсан бөгөөд анх Хөдөлмөр, цалин хөлсний Улсын хороо, МҮЭ-ийн төв зөвлөлийн 1962 оны 32/131 дүгээр тогтоолоор “Хөдөлмөрийн хортой, хүнд, халуун нөхцөлийн жагсаалт”-ыг баталж улмаар дээрх хоёр байгууллагын 1971 оны 185/142 дугаар тогтоолоор Эрүүлийг хамгаалах яам, Сангийн яамтай зөвшилцөн “Улсын тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох ажил, мэргэжил, албан тушаалын жагсаалт” болгон өөрчилж шинэчлэн баталж мөрдөж байсан.

1971 онд баталсан энэхүү жагсаалтыг 1995 он хүртэл мөрдөхөд нийтдээ 35 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын 1995 оны 78 дугаар тушаалаар өөрчлөн баталсан.

Улмаар Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар “Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-ыг шинэчлэн баталж өнөөдрийг хүртэл мөрдөж байна. Энэ хугацаанд уг жагсаалтад нийтдээ 8 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэлэлцэн баталсан бөгөөд хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт “Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт, хэрэглэх журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Жагсаалт, журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төсөл, жагсаалт, журмын төслийг тус тус боловсруулав.

Дээрх жагсаалтыг боловсруулахдаа Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт /УАМАТ/-08-тай уялдуулан ангилж кодолсон болно.

Олон Улсын Ажил, мэргэжлийн стандарт ангилал /ISCO-08/ нь 2008 онд шинэчлэгдэн батлагдсан. Монгол Улсад мөрдөж байгаа Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт /YAMAT-08/ нь ISCO-08-ын үндсэн бүтцийг авч, нэгж бүлгийн ажил, мэргэжлийн ангиллыг үндэсний индекс/кодоор баяжуулан 2010 онд батлагдсан болно.

Энэхүү тушаал батлагдсанаар даатгуулагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.1.4-5.1.6-д заасан нөхцөл болзолгоор өндөр насны тэтгэвэр тогтоож, олгох зорилготой юм.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ